

25

“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВИЙГ НИЙСЛЭЛТЭЙ ХОЛБОСОН АВТО ЗАМЫН “ШАР ТЭЭГ”-ИЙН УУЛЗВАРААС ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ 59.6 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 05/21

Улаанбаатар хот

Энэхүү Гэрээ /цаашид “Нэмэлт гэрээ” гэх/-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар болон “Эн Си Эф” ХХК нарын хооронд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан “Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар Тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээ / цаашид “Концессын гэрээ” гэх/-ний 6.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 27-р тэмдэглэл, Сангийн яамны 2021 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 9/2891 дугаартай албан бичгээр ирүүлсэн санал болон “Эн Си Эф” ХХК-с 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 21/34, 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 21/56 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу,

Нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Х.Улам-Өрнөх,

Нөгөө талаас “Эн Си Эф” ХХК (РД: 5459966) /цаашид “концесс эзэмшигч” гэх/, түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Б.Тулга-Эрдэнэ нар Концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

- 1.1. Концессын гэрээний 1.7 дахь заалтын “2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө” гэснийг “2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө” гэж өөрчлөн найруулав.
- 1.2. Концессын гэрээний 1.13-т заасан эргэн төлөлтийн хуваарийг дараах хүснэгтэд заасны дагуу өөрчлөв.

№	Төлбөрийн дүн /ам.доллар/	Төлбөрийн дүн /үсгээр/	Төлбөр гүйцэтгэх огноо
1	28,737,832.00	Хорин найман сая долоон зуун гучин долоон мянга найман зуун гучин хоёр	2022 оны 06 сарын 30-ны өдрөөс өмнө
2	7,184,458.00	Долоон сая нэг зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун тавин найм	2023 оны 06 сарын 30-ны өдрөөс өмнө

- 1.3. Концессын гэрээний 2.28-д “Концесс эзэмшигч нь зөвлөхийн үлдэгдэл зардлыг Эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд нэн даруй шилжүүлэх үүрэгтэй.” гэснийг “Концесс эзэмшигч нь зөвлөхийн үлдэгдэл зардлыг Эрх бүхий этгээдийн дансанд дараах хуваарийн дагуу шилжүүлэх үүрэгтэй.” гэж өөрчлөн найруулав.

№	Төлбөрийн дүн /төгрөгөөр/	Төлбөрийн дүн үсгээр	Төлбөр гүйцэтгэх огноо
1	150,000,000.00	Нэг зуун тавин сая	2021 оны 06 сарын 11-ний өдөр
2	300,000,000.00	Гурван зуун сая	2021 оны 07 сарын 05-ны өдөр
3	500,000,000.00	Таван зуун сая	2021 оны 08 сарын 15-ны өдөр
4	965,842,612.00	Есөн зуун жаран таван сая найман зуун дөчин хоёр мянга зургаан зуун арван хоёр	2021 оны 09 сарын 10-ны өдөр

- 1.4. Концессын гэрээний 2.29-д “Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 2.28-д заасан хугацаанд зөвлөхийн үлдэгдэл зардлыг эрх бүхий этгээдэд шилжүүлээгүй тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд зөвлөхийн үлдэгдэл зардлын үнийн дүнгийн 0.01%-ийн алдангийг Эрх бүхий этгээдэд төлнө. Эрх бүхий этгээд нь алдангийг концесс эзэмшигчид өгөх төлбөрөөс үл маргах журмаар суутган авна.” гэсэн заалт нэмэв.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

86

- 2.1. Энэхүү Нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад концессын гэрээний зохицуулалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 2.2. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Концессын гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.3. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 2 үйлдэгдсэн бөгөөд концессын гэрээний хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ
Гарын үсэг:

Нэр: Х.Улам-Өрнөх
Албан тушаал: Төрийн худалдан авах
ажиллагааны газрын дарга

Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
Гарын үсэг:

Нэр: Б.Тулга-Эрдэнэ
Албан тушаал: "Эн Си Эф" ХХК
-ийн Гүйцэтгэх захирал

Тамга:

